ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 16 өдөр Дугаар А/05 Сайншанд

2025 оны ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь заалт, 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хороод, Зөвлөл, Ажлын албаны 2025 оны ажлын төлөвлөгөөг 1 дүгээр, Иргэний танхимын 2025 оны ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын төлөвлөгөөнд заагдсан тодорхой ажлуудыг сар, улирлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж иргэд, байгууллагын санаачилгыг идэвхжүүлэн ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл, Хороод, Төлөөлөгчид, Ажлын албанд үүрэг болгосугай.

3. Ажлын төлөвлөгөөнд тусгагдсан зорилт бүрийг хэрэгжүүлэхэд бүх шатанд хамтран ажиллахыг баг, байгууллагын дарга, эрхлэгч, албан хаагчид, ард иргэдэд уриалсугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4625001006

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын
2025 оны 01 сарын 16 ны өдрийн А/05 дугаар
Захирамжийн нэгдүгээр хавсралт

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ИТХ, ХОРООД, ЗӨВЛӨЛ АЖЛЫН АЛБАНААС 2025 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго нь: Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж, төлөвшүүлэн орон нутгийнхаа нийгэм эдийн засгийг хөгжүүлэн, ард иргэдийнхээ төлөөлүүлэх эрхийг хангана.

№	Боловсруулах бодлого, гарах шийдвэр, хийх ажлын үндсэн чиглэл	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцан зохион байгуулах эзэн	Хяналт тавих хүн
Нэг. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанаар хэлэлцэх асуудал				
1	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит гурав, дөрөв, тав, зургаадугаар хуралдаануудыг хуралдуудах	1, 2, 3, 4 улиралд	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
2	ИТХ-ын хуралдаанаар Хонгорын голын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл сонсох	2-3 улиралд	Засаг даргын Тамгын газрын байгаль хамгаалагч	ИТХ-ын дарга
3	Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих дэд хөтөлбөрүүд батлах	1-р улиралд	Засаг дарга	ИТХ-ын дарга
4	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ажлын тайлангийн хэрэгжилт дүгнэх	4-р улиралд	ИТХ-ын дарга	ИТХ-ын төлөөлөгчид
5	Сумын Засаг даргын 2024-2028 онд баримтлан ажиллах үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг сонсох үнэлэх	4-р улиралд	Засаг дарга	ИТХ-ын дарга
6	Сэврэй сумыг 2023-2032 онд хөгжүүлэх сумын дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөгөөний хэрэгжилтийн явцтай танилцах	4-р улиралд	Засаг даргын орлогч	ИТХ-ын дарга
7	2025 оны сумын хөгжлийн төлөвлөгөөний явцтай танилцах, хэрэгжилт дүгнэх, 2026 оны сумын хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай	2, 4-р улиралд	Засаг даргын орлогч	ИТХ-ын дарга
8	Сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт дүгнэх, 2026 оны төлөвлөгөө батлах	12 дугаар сард	ЗДТГ-ын Газрын даамал	ИТХ-ын дарга
9	Сумын 2024 оны төсвийн гүйцэтгэл, 2025 оны төсвийн тодотгол, 2026 оны төсөв батлах	7, 12 дугаар сард	ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга	ИТХ-ын дарга
10	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүд	4-р улиралд	Дэд хөтөлбөрийг хариуцаж	ИТХ-ын дарга

	дүгнэх		байгаа албан тушаалтнууд	
11	Сумын улсын тусгай хамгаалалттай газар нутгийг нэмэгдүүлэх талаар гаргасан тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох шаардлагатай бол дахин хэлэлцэж дээд шатанд уламжлах	1-р улиралд	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн, ЗДТГ-ын байгаль хамгаалагч	ИТХ-ын дарга
12	Сумын соёлын өвийн хадгалалт хамгаалалтын талаар сонсох, хамгаалалтын бүс тогтоох талаар хэлэлцэх	1-р улиралд	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн, Соёлын төвийн эрхлэгч	ИТХ-ын дарга
13	Бэлчээрийн даацын судалгаа хийх ажлын хэсгийн мэдээлэл сонсох	1-р улиралд	Ажлын хэсгийн ахлагч	ИТХ-ын дарга
14	Уст цэгүүдийн хамгаалалтын зурвасын талаар мэдээлэл сонсож шаардлагатай цэгүүдийг нэмж хамгаалалтанд авах талаар хэлэлцэх	1-р улиралд	Сумын ЗДТГ-ын байгаль хамгаалагч	ИТХ-ын дарга
15	Сумын Тэмээ өсгөх бодлогын хэрэгжилт сонсох	1-р улиралд	ХАА-н тасаг С.Мөнхсайхан	ИТХ-ын дарга
16	Сумын орчны бүсийн зөвлөлийг шинэчлэн байгуулах, орчны бүсийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг сонсох	1, 3-р улиралд	Орчны бүсийн зөвлөлийн дарга	ИТХ-ын дарга
17	Сумын ИТХ-ын тогтоолуудаас хяналтаас гарах болсон тогтоолуудыг хяналтаас хасах тухай хэлэлцэх	3-р улиралд	ЗДТГ-ын хууль эрх зүйн мэргэжилтэн	ИТХ-ын дарга
18	Баг, байгууллагуудын үйл ажиллагааны тайланг сонсох хэлэлцэх. /Тухайн сарын онцлох 10 ажил, ирэх сард хийж хэрэгжүүлэх ажил, төсөв санхүүгийн байдал/	Сар тутам /сарын бүрийн эхний 7 хоногийн пүрэв гарагт/	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
19	Сумын сангуудын болон, Шилэн дансны гүйцэтгэлд хяналт тавьж, мэдээллийг хэлэлцэх	- Улирал тутам - Сар бүр	ЗДТГ-ын Санхүү албаны дарга	ИТХ-ын дарга
20	Сумын төсөвт орон нутгийн өмчит байгууллагууд 2024 оны санхүүгийн тайлан тушаасан мэдээлэлтэй танилцах	2-р улиралд	Төсөвт орон нутгийн өмчит байгууллагуудын нягтлан бодогчид	ИТХ-ын дарга
21	Сумын орон нутгийн өмчит байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл сонсох	Хагас бүтэн жилээр	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
22	Сумын ИТХ-аас батлан гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг	Хагас бүтэн жилээр	ЗДТГ-ын хууль эрх	ИТХ-ын дарга

	тооцон тайланг хэлэлцэх		зүйн мэргэжилтэн	
23	Дээд шатны байгууллагуудаас гаргасан зарлиг, тогтоол, захирамж, албан даалгавар, шийдвэрийн хэрэгжилтийн мэдээлэл сонсох	Хагас бүтэн жилээр	ЗДТГ-ын хууль эрх зүйн мэргэжилтэн	ИТХ-ын дарга
24	Сумын нийгмийн даатгалын сангийн мэдээлэл сонсох, Тэтгэвэрт гарах иргэдийн судалгаатай танилцах	Хагас бүтэн жилээр	ЗДТГ-ын Нийгмийн даатгалын байцаагч	ИТХ-ын дарга
25	Сумын халамжийн сангийн мэдээлэл, амьжиргаа дэмжих зөвлөлийн ажлын мэдээлэл сонсох	Хагас бүтэн жилээр	ЗДТГ-ын Хөдөлмөр халамжийн мэргэжилтэн	ИТХ-ын дарга
26	Сумын татварын орлогын мэдээлэл сонсох	Хагас бүтэн жилээр	ЗДТГ-ын Татварын байцаагч	ИТХ-ын дарга
27	ИТХ-ын дэргэдэх өргөдөл гомдлын хорооны ажлын мэдээллийг сонсох	Хагас бүтэн жилээр	Өргөдөл гомдлын хороо	ИТХ-ын дарга
28	Цагдаагийн байгууллага, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн тайланг хэлэлцэх	Хагас бүтэн жилээр	Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, цагдаа	ИТХ-ын дарга
29	ИТХ-ын дэргэдэх ОНХС-ийн хяналтын ажлын хэсгийн үйл ажиллагааны мэдээлэл сонсох	Хагас бүтэн жилээр	Ажлын хэсгийн ахлагч	ИТХ-ын дарга
30	ЕБС-ийн Насан туршийн боловсролын багшийн жилийн ажлын мэдээлэл сонсох	Бүтэн жилээр	Насан туршийн болосролын багш	ИТХ-ын дарга
31	Хоршоо хөгжүүлэх сангаар тухайн жилд хэрэгжүүлэх жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэл, нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээ болон төсөл сонгон шалгаруулах товыг тогтоож, төсөл сонгон шалгаруулах болон хяналт тавих зөвлөлийн ажлын тайланг сонсон хэлэлцэх	1-р улиралд, улирал бүр	ЗДТГ-ын ХАА-н тасаг Хяналтын зөвлөл	ИТХ-ын дарга
32	Сумын статистик тоон мэдээ, статистик судалгааны ажлын талаар тайлан мэдээлэл сонсох /Статистикийн хуулийн дагуу нууц тоон мэдээлэл орохгүй/	Бүтэн жилээр	Статистик төрийн сангийн мэргэжилтэн	ИТХ-ын дарга
33	Сумын цаг уурын жилийн ажиглалтын мэдээлэл сонсох	Бүтэн жилээр	Цаг уурын харуул	ИТХ-ын дарга
34	Сумын Залуучууд хөгжлийн төвийн ажлын мэдээлэл сонсох	Бүтэн жилээр	Залуучууд хөгжлийн төвийн ажилтан	ИТХ-ын дарга
35	Сумын хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан багийн ажлын мэдээлэл сонсох	Бүтэн жилээр	ЗДТГ-ын Нийгмийн ажилтан	ИТХ-ын дарга
36	Сумын эрүүл мэндийн салбар зөвлөлийн ажлын мэдээлэл сонсох	Бүтэн жилээр	ЭМТ-ийн эрхлэгч	ИТХ-ын дарга

37	Хонгорын голын хөгжил ТББ-ын Хонгорын голын нэвтрэх цэгийг ажиллуулсан ажлын мэдээлэл сонсох	Бүтэн жилээр	Хонгорын голын хөгжил ТББ-ын гүйцэтгэх захирал	ИТХ-ын дарга
38	Суманд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн байгууллагуудын үйл ажиллагааны тайланг сонсох	Бүтэн жилээр	Мал эмнэлгийн захирлууд	ИТХ-ын дарга
39	Суманд үйл ажиллагаа явуулж буй ТХГНХЗ ны байгаль хамгаалагч нарын ажлын мэдээллийг сонсох	Бүтэн жилээр	ТХГНХЗ ны байгаль хамгаалагчид	ИТХ-ын дарга
40	Суманд үйл ажиллагаа явуулж буй ӨБЦТС ТӨК ажилтнуудын ажлын мэдээллийг сонсох	Бүтэн жилээр	ӨБЦТС ТӨК ажилтнууд	ИТХ-ын дарга
41	Сумын өмч хамгаалах зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг сонсох, орон нутгийн өмч хөрөнгийн бүртгэл ашиглалт хамгаалалтын талаар мэдээлэл сонсох, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн актлах, шилжүүлэх, уламжлах.	1,4-р улиралд	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга	ИТХ-ын дарга
42	Хороодын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж, хороод болон Төлөөлөгч нарын жилийн ажил, үйл ажиллагааг үнэлж дүгнэх журмын дагуу төлөөлөгчийн ажлын тайланг хүлээн авч сонсох, оны тэргүүний Хороо, ИТХ-ын төлөөлөгчийг шалгаруулах	12 дугаар сард	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
43	Шаардлагатай үед бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх	Тухай бүр	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
Хоёр. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хороодын үйл ажиллагаа				
1	ИТХ-ын төлөөлөгчдийн Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх явцад санаачилга гарган ажиллах, жилийн төлөвлөгөө боловсруулж батлуулан хэрэгжүүлж ажиллах	Тухай бүр	Ёс зүйн хорооны дарга	ИТХ-ын дарга
2	Боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, өрх гэр бүлийн хөгжил, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн салбарын бодлого үйл ажиллагааны мэдээлэл тайланг сонсох, санал дүгнэлт гаргах, асуудал санаачлах, жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлж ажиллах	Тухай бүр	Нийгмийн бодлогын хөгжлийн хорооны дарга	ИТХ-ын дарга
3	Төсөв, өмч хөрөнгө, шилэн дансны хууль, татварын орлого бүрдүүлэлт,	Тухай бүр	Эдийн засаг, өмч, төсөв	ИТХ-ын дарга

	орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хэрэгжилтийн явц, худалдан авах ажиллагаанд иргэд олон нийтийн оролцооны мэдээлэл тайланг сонсох, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр санал дүгнэлт гаргах, асуудал санаачлах, жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлж ажиллах		санхүү, дэд бүтцийн хөгжлийн хорооны дарга	
4	Аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгальд эзлтэй аялал жуулчлалын сүлжээг өргөжүүлэх, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг ашиглах, агаарын бохирдол, хог хаягдал байгаль орчны чиглэл, мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх, газар зохион байгуулалтын чиглэлийн мэдээлэл тайланг сонсох, санал дүгнэлт гаргах, асуудал санаачлах, жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлж ажиллах	Тухай Бүр	Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны дарга	ИТХ-ын дарга
Гурав. Сумын ИТХ, Хороод, Зөвлөлөөс хийх хяналт шалгалтын талаар				
1	ИТХ-ын төлөөлөгчдийг Ёс зүйн дүрмээ баримтлан ажиллаж байгаа эсэхэд болон, сумын хэмжээний өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад хяналт тавих	Тухай бүр	Ёс зүйн хорооны дарга	ИТХ-ын дарга
2	Төрийн үйлчилгээний байгууллагууд ард иргэдэд үйлчилж буй байдал, ахмад настан, иргэд, хүүхэд залуучуудын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх талаар хийгдэж буй ажилд хяналт тавих, үр дүнг тооцох	Тухай бүр	Нийгмийн бодлогын хөгжлийн хорооны дарга	ИТХ-ын дарга
3	Төсвийн орлогын бүрдүүлэлт, татвар ногдуулалтад, төсвийн зарцуулалт, тендер худалдан авах ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хоршоо хөгжүүлэх сангийн төсөл хэрэгжилт, дэд бүтцийн талаар хяналт хийх, үр дүнг тооцох	Тухай бүр	Эдийн засаг, өмч, төсөв санхүү, дэд бүтцийн хөгжлийн хорооны дарга	ИТХ-ын дарга
4	Аялал жуулчлалын үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа, хөдөө аж ахуйн чиглэлийн үйл ажиллагаанд хяналт хийх, үр дүнг тооцох	Тухай бүр	Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны дарга	ИТХ-ын дарга
Дөрөв. ИТХ-ын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал				
1	Сумын ИТХ-ын хуралдааны товыг хэлэлцэн тогтоож, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан хэлэлцэж хэлэлцэх асуудлын	Тухай бүр	ИТХ-ын Нарийн бичгийн дарга,	ИТХ-ын дарга

	дарааллыг тогтоох		мэргэжилтэн	
2	Сумын ИТХ-ын Хороодын хуралдааны тов, хуваарийг хэлэлцэх батлах	Тухай бүр	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
3	Сумын ИТХ-ын хуралдааны шийдвэрийн биелэлтийн явц, үр дүнтэй танилцах, биелэлтийг хангуулахаар холбогдох хороод, ажлын хэсэг, байгууллага, албан тушаалтанд үүрэг чиглэл өгөх	Тухай бүр	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
4	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцэхээр 1-р хэсгийн 18-43 дугаарт тусгагдсан асуудлуудаас хууль тогтоомжийн дагуу хэлэлцэх боломжтой асуудлыг сар, улиралд багтаан хэлэлцэж, шаардлагатай мэдээллийг сонсох.	Тухай бүр	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
5	Хууль тогтоомжид заагдсан бусад асуудлыг хэлэлцэх	Тухай бүр	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
6	ИТХ-ын ахмад төлөөлөгчид болон иргэдийг төрийн болон яам салбарын шагналд тодорхойлох талаар хэлэлцэх	1,3-р улиралд	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
Тав . ИТХ, Хороод, Зөвлөл, Ажлын албанаас зохион байгуулах бусад ажил				
1	Дээд шатны байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийг сурталчлах, сумын ИТХ-аас батлан гаргасан тогтоол, шийдвэрүүдийг сурталчлах	Тухай бүр	ИТХ-ын Төлөөлөгчид, Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
2	Иргэний танхимын ажлын төлөвлөгөөг батлан тогтмолжуулан ажиллуулж, сайжруулж иргэдийн дунд хэлэлцүүлэг, санал асуулга зохион байгуулах	Жилдээ	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
3	Сумын 2026 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг эрэмбэлэх санал асуулга, хэлэлцүүлэг явуулах	3-6 сард	Төлөөлөгчид ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
4	Өрх гэр бүлийг дэмжих жилийн хүрээнд хийгдэх ажлын санал асуулга явуулах, санал асуулгын үр дүнгээр тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлэх	1-6 сард	Төлөөлөгчид ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
5	Аялал жуулчлалаас сумын төсөвт болон иргэдэд орох орлогыг нэмэгдүүлэх талаар санал асуулга	1 улиралд	Төлөөлөгчид ИТХ-ын Нарийн	ИТХ-ын дарга

	зохион байгуулах, санал асуулгын үр дүнгээр тодорхой ажлууд хийж хэрэгжүүлэх		бичгийн дарга, мэргэжилтэн	
6	Сумын дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж төлөвлөгөөний хувийн хэрэг материалтай танилцах	1-р улиралд	Төлөөлөгчид ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
7	Суманд хийгдэж буй хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын явцад хяналт тавин ажиллах	Тухай бүр	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
8	ИТХ-ын төлөөлөгчдийг хууль эрх зүйн сургалт мэдээллээр хангах, туршлага судлуулах, чадавхижуулах	Жилдээ	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
9	Hural.mn сайтад ИТХурлын үйл ажиллагааны мэдээг тогтмол байршуулах	Тухай бүр	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
10	Мини парламентийн хавар намрын хуралдаануудыг хуралдуудах	5 сар, 11 сард	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
11	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэдийн дурсгалыг хүндэтгэх өдрөөр арга хэмжээ зохион байгуулах	9 дүгээр сарын 11	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
12	МУЗН-ийн анхан шатны хорооны үйл ажиллагааг чиглүүлэн явуулах	жилийн турш	МУЗН-ийн анхан шатны хороо	ИТХ-ын дарга
13	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагааг чиглүүлэн явуулах	жилийн турш	Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, цагдаа	ИТХ-ын дарга
14	Төлөөлөгчдийг тойрогтоо ажиллах нөхцөл боломжоор хангах	Жилдээ	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
15	Үндсэн хууль батлагдсан өдөрт зориулан сумын аварга шалгаруулах шатрын тэмцээн, 100 буудалт даамны тэмцээн, ЕБС-ийн сурагчдын гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулах	6, 11 дүгээр сард	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
16	Шинэ үндсэн хууль батлагдсан өдөрт зориулсан арга хэмжээ зохион байгуулах /Насанд хүрэгчдийн дунд буудлагын тэмцээн /	1 дүгээр сард	ИТХ-ын төлөөлөгчид	ИТХ-ын дарга

17	ИТХ-ын Төлөөлөгчид, Засаг дарга, Засаг даргын орлогч, багуудын Засаг дарга, Хурлын нарийн бичгийн дарга нарын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд бүртгэх	1-р сард	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга
18	Багийн Иргэдийн Нийтийн хуралдаануудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах	Улирал бүр	ИТХ-ын Нарийн бичгийн дарга, мэргэжилтэн	ИТХ-ын дарга

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны
өдрийн А/05 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ ИРГЭНИЙ ТАНХИМЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Хяналт тавих
Нэг. Иргэд, олон нийтээс санал авах чиглэлийн арга хэмжээ (хэлэлцүүлэг, уулзалт, цахим хурал)				
1.	Сумын ИТХ-ын дэргэдэх иргэний танхимын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах	1 дүгээр улиралд	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн) сумын ИТХ-ын төлөөлөгчид	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
2.	Шинээр дагаж мөрдөж буй хуулийн хэлэлцүүлэг	2 дугаар улиралд	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн) Иргэд, ТББ	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
3.	Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой уулзалтууд	Тухай бүр	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн) Холбогдох байгууллага, албан тушаалтан	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
4.	Сумын 2026 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг эрэмбэлэх санал асуулга, хэлэлцүүлэг явуулах	2 дугаар улиралд	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн) ЗДТГ-ын Санхүү алба, БЗД нар	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
5.	Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой иргэдээс санал авах үйл ажиллагаа	Тухай бүр	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн) Холбогдох байгууллага, албан тушаалтан	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
Хоёр. Сургалт				
1.	Сумын ИТХ-ын Төлөөлөгч нарт чадавхижуулах сургалт	1 дүгээр улирал	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн), Хурлын дарга, ИТХ-ын ажлын алба	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
2.	Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой цахим болон танхимын сургалтууд	Тухай бүр	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн) Холбогдох байгууллага, албан тушаалтан	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
3.	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх талаарх сургалт	1 дүгээр улиралд	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
4.	Суманд зохион байгуулагдах арга хэмжээ, сургалт уулзалтуудыг танхимаар ханган ажиллах	Тухай бүр	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн) Холбогдох байгууллага, албан тушаалтан	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
5.	Шинээр мөрдөж буй хуулиудын талаар сургалт явуулах	Улиралд 1 удаа	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
Гурав. Мэдээлэл сурталчилгааны чиглэлийн арга хэмжээ				
1.	Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл, сурталчилгааг иргэдэд хүргэх	Тухай бүр	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)

2.	Иргэний танхимд зохион байгуулагдах хэлэлцүүлэг, сургалт болон иргэдийн дунд зохион байгуулагдах арга хэмжээг цахим хэрэгслээр олон нийтэд сурталчлах	Тухай бүр	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
3.	Иргэдэд зориулсан гарын авлага, сургалт сурталчилгааны материалуудыг Иргэний танхимаар дамжуулан иргэдэд хүргэх	Тухай бүр	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
4.	Иргэний танхимын үйл ажиллагаатай холбоотой сумын ИТХ-аас батлагдсан тогтоол шийдвэрийн цахим мэдээллийн санг хөтөлж, иргэд, олон нийтэд сурталчлах	Тухай бүр	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)
5.	Цахим орчинд богино хэмжээний бичлэг оруулан сурталчлах	Тухай бүр	Ш.Бямбаа (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)	Ч.Оргбиш (ИТХ-ын дарга)